

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулагдсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх болно.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Хуулийн төлийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2.Практикт хэрэгжих боломж:

Энэхүү хуулийн төсөл нь одоо хэрэгжиж байгаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, үүнтэй холбоотойгоор жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын тайлагналыг хялбаршуулах, татвар төлөх хугацааг хойшлуулах, төлбөрийн баримтыг хуульд заасан хугацаанд цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлж, баталгаажуулсан татвар төлөгчийг урамшуулах зохицуулалтууд хуулийн төсөлд шинээр орсон. Эдгээр зохицуулалт нь татварын албаны зүгээс болон татварын эрх зүйн харилцаанд оролцогч хувь болон хуулийн этгээдүүд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулах шаардлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3.Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4.Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлага хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд /иргэн, хуулийн этгээд/ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно. Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс “зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.

2	Практикт хэрэгжих боломж	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх	Хуулийн төсөл дээр үнэлгээчид, хуулийн этгээд, үнэлгээний хуулийг хэрэглэх этгээдүүдтэй нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа зэрэг болно.	Хуулийн төсөлд зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5, 29.1.6, 29.1.7-д болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦСОН БАЙДАЛ

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл:

1. Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах;
2. Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох;
3. Хуулийг нэг мөр ойлгох зарчмын хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хэрэгжүүлэхэд энгийн хялбар, харилцан ил тод болгох үндсэн зорилготой байна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1. Иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалах

Нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олон улсын шинэлэг чиг хандлага, зарчимд нийцүүлэн оновчтой, хүртээмжтэй болгох замаар

иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг шаталсан хэлбэрээр 100 хүртэл хувиар буцаан олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

Зорилт-2. Бизнесийн идэвхжилийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагаагаа тэлэх боломжийг олгох

Аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн хомсдол, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бух нийтээрээ тэгш шударга тэлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

Зорилт-3. Хуулийг нэг мөр ойлгох зарчмын хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хэрэгжүүлэхэд энгийн хялбар, харилцан ил тод болгох үндсэн зорилготой байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуульд татвар ногдуулах орлогыг тодорхойлох болон худалдан авалтад төлсөн татварыг хасаж тооцох бүртгэлийн суурь ялгаатай байсныг ижил аккрузл суурьт шилжүүлсэн. Мөн олон төрлийн чөлөөлөлтийн заалтуудыг багасган, зөвхөн олон улсад түгээмэл ашиглагддаг стандарт чөлөөлөлтүүдийг тусгасан зэргээр хуулийн хоёрдмол утга бүхий зохицуулалтыг хасаж, хэрэгжүүлэхэд энгийн, хялбар болгосон.

Түүнчлэн ажилчдын хөгжил, хүний нөөцийн бодлогыг дэмжих, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь дэлхийн улс орнуудад хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэрэглээний татвар юм. Тус татварын тогтолцоо нь үйлдвэрлэлийн үе шат бүрийн нэмүү өртөгт ногдуулж, эцсийн хэрэглэгч болох иргэд хэрэглээндээ төлдөг бөгөөд аж ахуйн нэгжүүдийн хувьд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлсөн татварыг суутган авч түүнээс өөрсдийн худалдан авалтдаа төлсөн татварыг хасаж төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлдог.

Монгол Улс анх 1998 оноос нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар 2007, 2015 онд уг хуулийг шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна. Үүнээс хойш цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн инфляц, төгрөгийн ханш, хүүгийн түвшин нэмэгдэж, энэ үед голчлон бага, дунд орлоготой хувь хун, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих тухай асуудал чухал ач холбогдолтой байна. Иймд иргэдийн эцсийн хэрэглээндээ төлдөг нэмэгдсэн өртгийн албан татварын ачааллыг бууруулж, аж ахуйн нэгжүүдэд үүсгэж буй хүндрэлийг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болоод байна.

Монгол Улсын хувьд инфляцын түвшин жил бүр өсөн нэмэгдэж, 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 9 хувьд хүрсэн ба энэ нь голчлон бага дунд орлоготой

иргэн, өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж, тэдний бодит орлого, худалдан авах чадварыг бууруулж байна.

Олон Улсын Валютын сангаас нэмэгдсэн өртгийн албан татварын тогтолцоо сайн улс орноор Шинэ Зеланд Улсыг онцолсон байдаг. Тухайлбал, Шинэ Зеланд Улс нь бух бараа, үйлчилгээнд нэг ижил татварын хувь хэмжээгээр ногдуулж, татварын чөлөөлөлтийг хамгийн бага түвшинд байлгаснаар бух нийтээрээ тэгш шударга төлж, бизнес эрхлэхэд нэмэлт дарамт болдоггүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын хувьд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, мөнгөн хөрөнгийн хомсдолд орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалах болон хөрөнгө оруулалт шинээр татахад хүндрэл үүсэж байна. Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар аж ахуйн нэгжүүдийн 57 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай байгаа нь 2019 оныхтой харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн нийт аж ахуйн нэгжүүдийн 34 хувь буюу 32 мянга гаруй компани алдагдалтай ажилласан байна. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2019 оноос өрдөө 13 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иймээс дээрх нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд татварын бодлогын холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Түүнчлэн, өнгөрсөн 2023 оны байдлаар иргэдийн төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувийн буцаан олголтын урамшууллаар нийт 316 тэрбум төгрөгийг 1.7 сая иргэнд олгосон байна. Үүнээс хэрэглээ өндөртэй, чинээлэг хэсэг буюу нийт иргэдийн 13 хувь нь нийт буцаан олголтын 60 хувийг авсан байгаа нь өнөөгийн хэрэгжиж буй нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгон сайжруулах шаардлага үүсэж байна.

3. Ойлгомжтой байдлыг хангасан эсэх:

Хуулийн төсөл нь 8 бүлэг, 25 зүйлээс бүрдэх бөгөөд дараах агуулгатай байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл;
- Татвар төлөгч, түүнд үзүүлэх хөнгөлөлтийн талаар;
- Татвар суутган төлөгч, түүний бүртгэлийн талаар;
- Татвар ногдуулах бараа, ажил үйлчилгээний талаар;
- Худалдан авалтад төлсөн татварын хасалт, татварын эцсийн тооцоо хийх талаар;
- Татвар тайлагнах, төлөх, илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааны талаар;
- Тусгайлсан татварын харилцааны талаар;
- Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой (Бусад) асуудлуудыг тус тус багтана.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим санал хүлээн авсан. Хэлэлцүүлгийн үр дүнд суутган төлөгчийн босго нэмэгдүүлэх, үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн татварыг шууд хасах, ажил эрхлэлтийг дэмжсэн

хөшүүргийг бий болгох, орлого хүлээн зөвшөөрөх суурь зарчмыг өөрчлөх, бүх нийтээрээ жигд төлдөг байх зэрэг саналуудыг нийтлэг байдлаар ирүүлсэн байна.

Энэхүү нөхцөл байдлыг харгалзан татварын бодлогыг илүү уян хатан, ойлгомжтой болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өрхийн татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг илүү оновчтой, хүртээмжтэй болгох чиглэлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг шинэчлэх практик шаардлага үүсэж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдэж хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Хуулийн төсөлд холбогдох мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдал, логик уялдааг сайжруулах тал дээр ирүүлсэн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5, 29.1.6, 29.1.7-д болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан байдлыг шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байна.
3	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх.	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
4	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгаагүй байна.

5	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх,	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй байна.
---	---	---

- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус	Тийм	Төрийн байгууллагын зарим чиг үүргийг

	байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;		“мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага”-аар гүйцэтгүүлэхээр зохицуулах боломжтой.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тусгаагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;	Үгүй	Татварын ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгыг дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Шинэчлэн найруулсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн төсөл нь олон улсын шинэлэг зарчмыг нэвтрүүлэх, иргэн, өрхийн хэрэглээндээ төлдөг татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг хамгаалж, бизнес эрхлэхэд НӨАТ-нь нэмэлт дарамт үүсгэдэггүй, бүх нийтээрээ жигд, тэгш шударга төлдөг байх ба нэмэгдсэн өртгийн албан татварыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдийн хууль даган мөрдөлтийн түвшинтэй уялдуулан дотоодын болон импортын НӨАТ төлөх хугацааг 2 хүртэл сараар сунгах боломж олгосноор хамгийн их тулгамдаж буй мөнгөн хөрөнгийн дутагдал, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулах нөхцөл бүрдэнэ. Мөн ажилтны сургалт, мэргэшүүлэх болон тэдгээрийн хувийн хэрэгцээний тодорхой зардлыг НӨАТ-аас хасах боломжийг нээж, одоогийн мөрдөгдөж буй хуулиар хязгаарлагдаж буй үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн болон оршин суугч бус этгээдээс авсан ажил, үйлчилгээний НӨАТ-ыг хасалт хийх боломжийг бүрдүүлснээр аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа тэлэх татварын таатай орчныг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Татварын хуулийн шинэчлэл нь бизнес эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэж, аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дарамтыг бууруулж, бизнесийн идэвхжих, тэлэх бололцоог ханган, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Зөвлөмж

Санхүү, эдийн засаг, хууль зүйн шинжлэх ухааны харилцан уялдааг хангаж татвар төлөгчийн бизнесийн эрх зүйн орчныг сайжруулж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эрдэмтэн судлаачдын санал дүгнэлтийг гаргах нь хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой, мөн хуулийн төслийн зарим зүйл заалтын техникийн алдааг анхаарч засах зөвлөмжийг өгч байна.